ИОН НАМЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН
2026 ОНЫ ХОЁРДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 11 дугаар сарын 07 Дугаар 02 Улаанбаатар хот

Заавар, журам батлах тухай

Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрмийн 11.5.11, 11.5.14 дэх заалт, тус хурлын Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн Төлөөлөгчдийн Танхимын хурлаас ТОГТООХ нь:

1. ИОН намын дүрэм хэрэгжүүлэх заавар /шинэчилсэн найруулга/-ыг 1-р хавсралтаар батлалсугай.

2. Маргаан таслах комиссын ажиллах журам /шинэчилсэн найруулга/-ыг 2-р хавсралтаар батлалсугай.

ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ДАРГА _____ Ц.БАТБОЛД

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА _____ Ч.ЧУНТ

2026 оны 11 сарын 7-нд
хуралдсан
ИОН намын Төлөөлөгчдийн Танхимын
2026 оны 2-р хурлын
2-р тогтоолын 2-р хавсралт

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
МАРГААН ТАСЛАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ
(Шинэчилсэн найруулга)

Нэг. Маргаан таслах комисст хандах, маргааныг хуралд оруулах, маргааны оролцогч.

1.1. Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын Маргаан таслах комиссын үйл ажиллагаа ИОН намын дүрмийн 21-р зүйл болон энэ журамд заасны дагуу явагдана. Маргаан таслах комиссын эрх, үүргийн талаар ИОН намын дүрэмд дурдсан бусад заалтыг тус комисс мөрдөж ажиллана.

1.2. Маргаан таслах комисст хандсан бүх гомдлыг Маргаан таслах комиссын дарга legal@cup.mn хаягаар хүлээн авна.

1.3. Маргаан таслах комиссын хуралд гомдол гаргагч, хариуцагч талууд нотлох баримт, үндэслэлийг өөрсдөө бүрдүүлэх үүрэгтэй.

1.4. Маргаан таслах комиссын хуралд гэрч дуудаж асуухгүй, нүүрэлдүүлэх, таниулах, хөндлөнгийн шинжилгээ хийлгэх ажиллагаа, үзлэг явуулахгүй бөгөөд гуравдагч этгээдийн өгсөн мэдээлэл, дүгнэлт, баримтыг хэргийн оролцогч бичгээр бүрдүүлэх материалд хавсаргаж болно.

1.5. Маргаан таслах комиссын хуралд оролцох намын гишүүн өмгөөлөгч, дохионы хэлний орчуулагч, харааны бэрхшээлтэй үед туслах туслагчийн хамт оролцож болно. Оролцогч өөрийгөө итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно.

1.6. Маргаан таслах комиссын хурал зайлшгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд цахимаар хуралдана. Хурлын линкийг Маргаан таслах комиссын дарга намын Ерөнхий менежерт хандан захиалж, тус линкийг хуралдахаар оноолт таарсан гишүүдэд болон маргааны оролцогч нарт и-мейлээр илгээнэ.

1.7. Маргааны оролцогч гэж гомдол гаргасан гишүүн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч, олон гишүүн хамтдаа гомдол гаргасан бол тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч, хариуцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарыг хэлнэ.

1.8. Илтгэгч гишүүнээс бусад Маргаан таслах комиссын гишүүд талуудын маргаан өрнүүлэх материалыг урьдчилан уншихгүй.

1.9. Талууд нотлох баримтынхаа хуулбарласан хувийг маргааны нөгөө талд хангалттай хугацааны өмнө харилцан гарган өгч түүнд нь няцаалт бэлдэх, эсвэл маргааныг харилцан буулт хийж хурлаас гадуур шийдэх боломжийг олгоно. Өмнө нь ил болсон байсан хэдий ч маргалдагч нөгөө талд

хүргүүлээгүй нотлох баримтыг маргаан таслах шийдвэр гаргахад иш үндэс болгохгүй. Гэнэтийн гэнэдүүлсэн баримт гаргаж ирэх аргыг маргаан таслах хурлын үеэр ашиглахыг хориглоно.

Хоёр. Маргаан таслах комиссын хурал, шийдвэр

2.1 Маргаан таслах комиссын хурал нээлттэй хуралдана. Намын гишүүд хурал үүссэн линкийг намын апп—аас хүлээн авч хуралд ажиглагчаар оролцож болно.

2.2 Маргаан таслах комиссын хурал дараах горимоор явагдана:

2.2.1 Хурлыг маргаан таслах комиссын дарга нээх, тухайн хурлаар хэлэлцэх асуудал, асуудлыг хуралд оруулж буй илтгэгч гишүүнийг танилцуулах.

2.2.2 Оролцогч нарын зүгээс Илтгэгч гишүүнийг татгалзах эсэхийг лавлах

2.2.3 Маргаан таслах комиссын илтгэгч гишүүнийг татгалзсан тохиолдолд хурлыг хойшлуулах.

2.2.4 Маргаан таслах комиссын илтгэгч гишүүнийг татгалзаагүй тохиолдолд хурлыг үргэлжлүүлнэ.

2.2.5 Илтгэгч гишүүний танилцуулгыг сонсох. Илтгэгч гишүүний танилцуулгад дараах мэдээлэл багтсан байна. Үүнд:

а. гомдол гаргагч нь МТК-д гомдол гаргах эрхтэй субьект мөн эсэх,

б. гомдлын шаардалага нь дүрэмд заасан МТК-аар авч хэлэлцэх хүрээнд тавигдсан эсэх,

в. холбогдох нотлох баримт ирүүлсэн эсэх,

г. хариуцагч хэн болох,

д.гомдол гаргагч өөрийн гомдлын шаардлага болон нотлох баримтын хувийг хариуцагч талд хангалттай хугацааны өмнө илгээсэн эсэх,

е.хариуцагч үүний дагуу няцаалт баримт ирүүлсэн эсэх, тухайн няцаалт баримтыг гомдол гаргагч талд хүргүүлсэн эсэхийг тус тус танилцуулна.

2.2.6 Гомдол гаргагчийн санал, хүсэлтийг сонсох

2.2.7 Хариуцагчийн санал хүсэлтийг сонсох

2.2.8 Маргаан таслах комиссын хуралд оролцож буй гишүүд оролцогчдоос танилцуулга, санал хүсэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авах.

2.2.9 Нотлох баримтыг шинжлэх хэсэг эхэлснийг Маргаан таслах комиссын дарга зарлах. Маргааны оролцогч нар нотлох баримтын тодорхой хэсгийг үзүүлж, тайлбарлаж, уншиж болох ба, уншиж өгөхийг Илтгэгч гишүүнээс хүсч болно гэдгийг зарлах.

2.2.10 Гомдол гаргагч нотлох баримтаас онцлох хэсгийг хуралд танилцуулах.

2.2.11 Хариуцагч нотлох баримтаас онцлох хэсгийг хуралд танилцуулах

2.2.12 Оролцогч талууд нөгөө талынхаа танилцуулсан нотлох баримтын тайлбарт нэмэлт тайлбар, няцаалт хийх, нотлох баримтад гэнэтийн, гэнэдүүлсэн баримт байгаа гэж үзвэл энэ тухай хуралд мэдэгдэх.

2.2.13 Илтгэгч гишүүн талуудын танилцуулсан нотлох баримт МТК-т ирсэн эсэх, гэнэтийн биш байсан эсэхийг нотолж үг хэлэх. Хэрэв гэнэтийн гэнэдүүлсэн нотлох баримт танилцуулагдвал түүнийг хуралд заавал мэдэгдэнэ.

2.2.14 Гэнэтийн гэнэдүүлсэн нотлох баримт гарч ирсэнийг Илтгэгч гишүүн

танилцуулсан даруйд МТК-ийн хурлыг дахин товлож шинээр хуралдуулах нөхцөл үүссэн болохыг МТК-ийн дарга мэдэгдээд хурлыг хаана. Хэрэв бүх нотлох баримт гэнэтийн бус, харилцан танилцсан нотлох баримт байгаа тохиолдолд МТК-ийн хурлыг үргэлжлүүлнэ.

2.2.15 Нотлох баримттай холбоотой асуултыг Маргаан таслах комиссын гишүүд оролцогчдоос асууж хариулт авах.

2.2.16 Оролцогч талууд хаалтын үг хэлэх. Хаалтын үг хэлэх дарааллыг хурал даргалагч тогтооно. Хаалтын үгийг оролцогч бүх талууд хэлэх эрхтэй байна.

2.2.17 Маргаан таслах комиссын гишүүд зөвлөлдөх өрөөнд хаалттай зөвлөлдөх. Цахим хурлын талбарт маргаан таслах комиссын гишүүд тусдаа өрөө үүсгэн зөвлөлдөх боломжийг хангасан байна.

2.2.18 Хэлэлцэж буй асуудлаар гомдлын шаардлага “үндэслэлтэй”, “үндэслэлгүй” гэсэн саналаар ил санал хураалт явуулж гуравны хоёрын саналаар шийдвэр гаргана. Гарсан шийдвэрт үндэслэн Маргаан таслах комиссын дүгнэлт, эсхүл зөвлөмжийг Илтгэгч гишүүн томьёолно.

2.2.19 Маргаан таслах комиссын хурлын дүгнэлт, зөвлөмжийг хуралд оролцогчдод танилцуулах.

2.3 Маргаан таслах комиссын хурлын шийдвэрийн төслийг Илтгэгч гишүүн ажлын ажлын 3 хоногт багтаан бичгээр гаргаж, хурлын шийдвэрт МТК-ийн дарга, илтгэгч гишүүн нар гарын үсэг зурна.

2.4 МТК-ийн хурлын шийдвэрийг оролцогч талуудын намын апп-д бүртгэлтэй и-мейл хаяг руу, хариуцах намын байгууллагад тус байгууллагын даргын намын апп-т бүртгэлтэй и-мейл хаяг руу тус тус илгээнэ.

2.5 Нэг шийдсэн асуудлаар дахин гомдол ирсэн тохиолдолд Илтгэгч гишүүнийг өөрчилж томилно.

2.6 Нэг хариуцагч этгээдийн эсрэг нэг ижил асуудлаар олон хүн зэрэг гомдол гаргасан бол хамтын зарга болгон авч үзэж, нэг илтгэгч гишүүнд хуваарилан хамтад нь хуралд оруулж болно.

2.7 Хамтын зарга үүсгэж шийдвэрлэсэн асуудлаар тухайн хамтын заргын оролцогч байсан этгээдээс ижил утгатай гомдол ирсэн тохиолдолд тухайн гомдлоор шинэ хэрэг үүсгэхгүй.

Гурав. Маргаан таслах комиссын үйл ажиллагааны төсөв

3.1 Маргаан таслах комиссын дарга жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор дараа жилийн үйл ажиллааны төсвийг төлөвлөж намын санхүүчид хүлээлгэн өгнө.

3.2 Маргаан таслах комиссын төсөвт дараах зардлыг багтааж болно:

3.2.1 Хурлын бэлтгэл хангах урсгал зардал

3.2.2 Маргаан таслах комиссын гишүүдийн урамшуулал

3.2.3 Сонгуулийн үеэр бүтэн ба илүү цаг ажиллах цагийн урамшуулал, өдрийн зардал (per diem);

3.2.4 Сонгуулийн үеэр ажиллах шуурхай ажлын өрөө болон тоног төхөөрөмжийн түрээсийн зардал;

3.2.5 Маргаан таслах комиссын гишүүдийн хэрэглэх офисын програм хангамжийн

лицензийн төлбөр;

3.3 Маргаан таслах комиссын үйл ажиллагааны төсвийг тус комиссын саналд үндэслэн Төлөөлөгчдийн Танхим батална.

3.4 Маргаан таслах комиссын үйл ажиллагааны бодит зардал батлагдсан төсвөөс хэтрэх нөхцөл үүссэн тохиолдолд нэмэлт санхүүжилт хүссэн Маргаан таслах комиссын бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж гаргасан хүсэлтийг маргаан таслах комиссын дарга намын Ерөнхий менежерт гаргана.

3.5 Энэ журмын 3.4-т заасан хүсэлтийг хүлээж аваад намын ерөнхий менежер дараах үйл ажиллагааны аль нэгийг гүйцэтгэнэ:

3.5.1 Нэмэлт санхүүжилтийг тухайн жилийн намын батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүйгээр олгох;

3.5.2 Дараа оны төсөвт нэмж суулган нөхөж өгөх;

3.5.3 Намын төсөвт тодотгол хийлгэхээр Төлөөлөгчдийн танхимд оруулахыг хүсч Намын даргад уламжлах.

3.6 Маргаан таслах комисс нь тусдаа дансгүй байна. Маргаан таслах комиссын төсвийг намын ерөнхий менежер намын данснаас Маргаан таслах комиссын даргын зөвшөөрлөөр зарцуулна.

3.7 Маргаан таслах комисс үйл ажиллагаагаа Намын их хуралд тайлагнана.

3.8 Маргаан таслах комиссын санхүүгийн тайланг намын нэгдсэн санхүүгийн тайланд намын санхүүч нэгтгэнэ.

Дөрөв. Бусад зүйл.

4.1. Энэхүү журмыг 2026 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн мөрдөнө.